Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,939,196.3 мянган төгрөг болж 625,616.1 мянган төгрөгөөр буурсан нь мал эмнэлгийн ерөнхий газрын худалдан авалтаар 64,567.7 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн багаж тоног төхөөрөмжөөр нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 706 дугаар тогтоолын дагуу ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 134,609.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталснаар буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 27,943.5 мянган төгрөг болж 26,857.5 мянган төгрөгөөр өссөн нь гуравдугаар зэрэглэлийн лабораторийн барилгын гал гарсан хэсгийг сэргээн засварлах ажлын гүйцэтгэлтэй холбоотой өглөг үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,674,011.3 мянган төгрөг болж 1,467,662.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1,478,605.6 мянган төгрөгөөр буурсан нь өөрийн үйл ажиллагааны орлого ковид-19 цар тахалтай холбоотой махны экспорт буурч шинжилгээний тоо багассантай холбоотойгоор төлөвлөснөөс 139,991.4

мянган төгрөгөөр дутуу, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оноос 823,199.6 мянган төгрөгөөр буурсан зэргээс шалтгаалсан байна .

Нийт зардал өмнөх оноос 1,216,156.1 мянган төгрөг буюу 33.8 хувиар өссөн нь өмнөх онуудад зарцуулсан 957,928.1 мянган төгрөгийн бараа материал, эм бэлдмэл, оношлуурыг тайлант хугацаанд данс бүртгэлээс хассан, малын гоц халдварт өвчний тандалт судалгаатай холбоотой эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгслийн зардал 514,048.7 мянга, гуравдугаар зэрэглэлийн лабораторийн барилгын гал гарсан хэсгийг сэргээн засахтай холбоотой бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 90,689.0 мянган төгрөгийг зарцуулсан зэргээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,966,099.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 218,128.7 мянган төгрөгөөр бууруулж, өмнөх оны төсвийн сууриар 1,747,970.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,747,970.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,569,376.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 178,594.4 мянган төгрөгийг, үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн тодотголоор 1,574,271.2 мянган төгрөг болгон бууруулж, улсын төсвийн санхүүжилтийг 1,021,676.8 мянган төгрөг болгон бууруулж, үндсэн үйл ажиллагаанаас орох орлогыг 552,594.4 мянган төгрөг болгон нэмэгдүүлж баталсан байна.

Энэ нь улс орны эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан байгууллагын үйл ажиллагааны орлого, үр ашгийг нэмэгдүүлэх, цалин хөлснөөс бусад тэвчиж болох зардал болон байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бараа материал, эд хогшил, урсгал засварын зардал, тоног төхөөрөмжийг шинэчлэхтэй холбогдох төсвийг 10-15 хувиар бууруулж баталсантай холбоотой байна.

Мөн 2021 оны 12 сарын төсвийн хуваарийн өөрчлөлтөөр ХХААХҮЯ-наас мэдээлэл технологийн зардалд Open.gov.mn төсвийн программын 2022 оны хөгжүүлэлтийн зардал болох 7,200.0 мянган төгрөгийг нэмж, тэтгэвэрт гарахад олгодог тэтгэмж урамшууллын зардлаас хэмнэгдсэн 29,500.0 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардлаас хэмнэгдсэн 6,400.0 мянган төгрөгийг Мал эмнэлгийн ерөнхий газарт шилжүүлэн хуваарилсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 992,976.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 412,602.9 мянган төгрөг, нийт 1,405,579.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,397,923.4 мянган төгрөгийг зарцуулж, 7,656.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг 147,647.7 мянган төгрөг буюу 9.6 хувиар хэмнэсэн нь үндсэн үйл ажиллагааны хөтөлбөр арга хэмжээ 146,051.0 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал хөтөлбөрийн арга хэмжээ 1,385.6 мянга, малын гоц халдварт өвчнөөс

урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн арга хэмжээ 6.7 мянга, малын архаг халдварт өвчнөөс сэргийлэх хөтөлбөрийн арга хэмжээг 2.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	80801	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,151,948.5	1,005,897.4	146,051.0	87.3
2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ				
3	80219	Харуул амгаалалтын зардал	5,000.0	5,000.0	00	100.0
4	80227	Лабораторын итгэмжлэл	7,152.2	6,950.0	202,2	97.2
5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	15,735.8	14,350.2	1,385.6	91.2
6	82506	Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	325,372.5	325,365.8	6.7	100.0
7	82507	Малын архаг халдварт өвчнөөс сэргийлэх	40,362.2	40,360.1	2.2	100.0
		Дүн	1,545,571.2	1,397,923.5	147,647.7	90.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 127,558.2 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 514,508.4 мянган төгрөг, нийт 642,066.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардалд 16,160.6 мянга, байр ашиглалтын зардалд 6,689.5 мянга, хангамж бараа материалын зардалд 16,478.9 мянга, нормативт зардалд 107,132.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 9,619.2 мянга, томилолтын зардалд 25,005.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 397,228.5 мянган төгрөг зарцуулж, 63,752.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори нь үндсэн 50, гэрээт 2 ажилтантай, захиргаа, санхүү, хангалтын алба, гоц халдварт өвчний оношилгоо, тандалтын алба, хүнсний аюулгүй байдал, байгаль орчноос шалтгаалах өвчний оношилгоо, тандалтын алба гэсэн албадуудаас бүрддэг.

Тайлант онд мал, амьтны гоц халдварт өвчний оношилгоог түргэн шуурхай найдвартай гаргах, гоц халдварт, архаг халдварт өвчний тандалт, вакцины дараах хяналт тандалтын

шинжилгээ хийх, онош баталгаажуулах үндсэн үйл ажиллагааны хүрээнд хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан тусгагдсан 4 зорилтын хүрээнд 40 арга хэмжээний хэрэгжилт 87.1 хувь, хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 90.4 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага дотоод хяналтын системийг оновчтой бүрдүүлж ажиллаагүйгээс бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдэлд бүртгэлээр тавих хяналт суларч, өмнөх онуудад зарцуулсан бараа материалын үлдэгдлийг зардалд тусгаж, тайлант хугацааны үр дүнг бууруулсан. Төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас халж, тэдний ажиллаагүй хугацааны цалин, хөдөлмөрийн хөлсийг нөхөн олгож төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй асуудал давтан гарч байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд 159 мэдээлэл байршуулахаас 111 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж, 35 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 10, зарлагын 1 удаагийн 9,258.9 мянган төгрөгийн мэдээлэл, дараа жилийн төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны тайланг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлаас бусад төсөвт зардлыг 16,9 хувиар хэмнэсэн байна.

Тайлант онд хийсэн худалдан авах үйл ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль” түүнтэй нийцүүлж гарсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байдал аудитаар илрээгүй боловч өмнөх жилийн худалдан авах ажиллагаатай холбогдсон зөрчлийн асуудал Авлигатай тэмцэх газар шалгагдаж байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 28,368.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн залруулах бичилт хийж, өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг биелүүлж ажиллах, эргэлтийн хөрөнгийн тооллогын үр дүнг санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнах зөвлөмж өгсөн. Өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 82 хувийн биелэлттэй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 734.5 мянган төгрөгийн төлбөрийн актны биелэлт 100 хувь, шилэн дансны цахим хуудсанд 130 мэдээг хугацаа хоцроож, 26 мэдээг байршуулаагүй зөрчилд өгсөн албан шаардлагын хэрэгжилт 92.0 хувь, Шүүхийн шийдвэрээр үндэслэлгүй ажлаас халагдсан ажилтанд олгосон 7,257,2 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх албан шаардлагын хэрэгжилт хэрэгжээгүй, 3,505.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	734.5	1	734.5	0	0	100
Албан шаардлага	2	7,257.2	2	-	1	7,257.2	50
Зөвлөмж	2	3,505.0	2	3,505.0	0	0	100
Нийт дүн	5	11,496.7	5	4,239.5	1	7,257.2	-

Өмнөх аудитаар үндэслэлгүй ажлаас халагдсан ажилтанд олгосон 7,257,2 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх албан шаардлага хэрэгжээгүй, тайлант онд зөрчлийг давтан гаргаж төрийн албан хаагчийг үндэслэлгүй ажлаас халсан нөхөн олговорт 9,258.9 мянган төгрөг олгосон байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Био-аюулгүйн гуравдугаар зэрэглэлийн лабораторийн агааржуулалтын шугам хоолой, тоног төхөөрөмж, барилгын гадна дотор сендвич галд өртсөнөөс 100 орчим сая төгрөгийн шууд хохирол гарсан байна. Одоогоор галын осол гэмтлийн шалтгаан, дүгнэлт мэргэжлийн байгууллагаас албан ёсоор гараагүй байна.

Байгууллагын зүгээс техникийн хэсгийг ажиллуулж унтраах үйлдэл хийхдээ техникийн ноцтой алдаа гаргаснаас галын осол гарах нөхцөл шалтгаан үүссэн байж болзошгүй гэж үзэж байгаа тул мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн хохирлын асуудлыг хэрхэн шийдсэн эсэхийг дараагийн аудитоор авч үзнэ.

4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,066,633.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 92,188.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,257.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 967,187.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 974,444.2 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 17,802.9 мянган төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Авлага дансны эхний үлдэгдлийг 26,494.5 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн
- Бараа материалын дансны эхний үлдэгдлийг 2,750.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Дээрхи 2 тайлагналтай холбоотой хуримтлагдсан үр дүнгийн эхний үлдэгдлийг 23,743.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан
- Хөрөнгийн түрээсийн орлогыг 3,600.0 мянган төгрөгөөр орлого үр дүнгийн тайланд дутуу тайлагнасан
- Тайлант хугацааны бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 27,943.5 мянган төгрөгөөр орлого үр дүнгийн тайланд дутуу тайлагнасан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төвлөрүүлэх шилжүүлэг 7,656.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

4.2 Төлбөрийн акт

Өмнөх оны аудитын тайлангаар шүүхийн шийдвэрээр үндэслэлгүйгээр ажлаас халагдсан ажилтанд олгосон 7,257.2 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, алдаа, зөрчлийг арилгах албан шаардлага өгснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Албан шаардлага

1. Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн шийдвэрээр үндэслэлгүйгээр ажлаас халагдсан ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 9,258.9 мянган төгрөг шилжүүлсэн. Энэ нь Захиргааны Ерөнхий хуулийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", 103.2 "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, албан шаардлагыг хүргүүлэх.

2. Байгууллагын удирдлага дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйгээс бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдэлд бүртгэлээр тавих хяналт суларч, өмнөх онуудад зарцуулсан бараа материалын үлдэгдэл 957,928.1 мянган төгрөгийг зардалд тусгаж, тайлант хугацааны үр дүнг бууруулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-р зүйлийн 2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана": түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/ гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн худалдан авалт, зарцуулалт, үлдэгдэлд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэх Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

/Мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	УМЭАЦТЛ	АХГ-2022/345/Н А-СТА-ТШЗ	Авллага дансны эхний үлдэгдлийг 26,494.5 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн	Авллага дансны эхний үлдэгдэлийг залруулсан	1	26,494.5	1	26,494.5						
2	УМЭАЦТЛ	АХГ-2022/345/Н А-СТА-ТШЗ	Бараа материалын дансны эхний үлдэгдлийг 2,750.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	Бараа материалын дансны эхний үлдэгдлийг залруулсан	1	2,750.6	1	2,750.6						
3	УМЭАЦТЛ	АХГ-2022/345/Н А-СТА-ТШЗ	Хуримтлагдсан үр дүнгийн эхний үлдэгдлийг 23,743.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	Хуримтлагдсан үр дүнгийн эхний үлдэгдлийг залруулсан	1	23,743.9	1	23,743.9						
4	УМЭАЦТЛ	АХГ-2022/345/Н А-СТА-ТШЗ	Хөрөнгийн түрээсийн орлогыг 3,600.0 мянган төгрөгөөр орлого үр дүнгийн тайланд дутуу тайлагнасан	Хөрөнгийн түрээсийн орлогыг залруулсан	1	3,600.0	1	3,600.0						
5	УМЭАЦТЛ	АХГ-2022/345/Н А-СТА-ТШЗ	Тайлант хугацааны бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 27,943.5 мянган төгрөгөөр орлого үр дүнгийн тайланд дутуу тайлагнасан.	Тайлант хугацааны бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг залруулсан	1	27,943.5	1	27,943.5						
6	УМЭАЦТЛ	АХГ-2022/345/Н А-СТА-ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төвлөрүүлэх шилжүүлэг 7,656.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	Төсвийн гүйцэтгэлийн тайланг төвлөрүүлэх шилжүүлгээр залруулсан	1	7,656.3	1	7,656.3						
7	УМЭАЦТЛ	АХГ-2022/345/Н А-СТА-ТШЗ	Өмнөх оны аудитын тайлангаар шүүхийн шийдвэрээр ажилтанд олгосон 7,257.2 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, алдаа, зөрчлийг арилгах албан шаардлага өгснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	Буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.	1	7,257.2			1	7,257.2				

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

8	УМЭАЦТЛ	АХГ-2022/345/Н А-СТА-ТШЗ	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн шийдвэрээр үндэслэлгүйгээр ажлаас халагдсан ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 9,258.9 мянган төгрөг шилжүүлсэн.	Төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, албан шаардлагыг хүргүүлсэн	1	9,258.9					1	9,258.9		
9	УМЭАЦТЛ	АХГ-2022/345/Н А-СТА-ТШЗ	Байгууллагын удирдлага дотоод хяналтыг оновчтой хэрэгжүүлээгүйгээс бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдэлд бүртгэлээр тавих хяналт суларч, өмнөх онуудад зарцуулан бараа материалын үлдэгдэл 957,928.1 мянган төгрөгийг зардалд тусгаж, тайлант хугацааны үр дүнг бууруулсан.	НББ-ийн тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулийн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах, тооллогын үр дүнг санхүүгийн тайлан тэнцэлд тусгаж байх, хөрөнгийн хадгалалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж ажиллах	1	957,928.1					1	957,928.1		
ДҮН					10	1,066,633.0	6	92,188.8	1	7,257.2	2	967,187.0		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	УМЭАЦТЛ	АХГ-2022/345/Н А-СТА-ТШЗ	Шилэн дансанд 35 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 11 удаагийн 358,998.0 мянган төгрөгийн мэдээлэл, дараа жилийн төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны тайланг байршуулаагүй .	Өмнө жилийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй тул хариуцлага тооцох албан шаардлага өгсөн.	1	9,258.9					1	9,258.9		
ДҮН					1	9,258.9					1	9,258.9		
НИЙТ ДҮН					11	1,075,891.9	6	92,188.8	1	7,257.2	3	976,445.9		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 34/АДИС 0458
АХГ-2022/345/НА-СА-ТМЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар шүүхийн шийдвэрээр ажилтанд олгосон 7,257,208.00 төгрөгийг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, алдаа, зөрчлийг арилгах албан шаардлага өгснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Захиргааны Ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5 гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", 103.2 "Энэ хуулийн 103.1 Гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Шүүхийн шийдвэрээр ажилтанд олгосон нөхөн олговор 7,257,208 /долоон сая хоёр зуун тавин долоон мянга хоёр зуун найман/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газрын дарга Б.Алтансүхт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264250

\\10.10.10.20\Bichig_Khereg\AK\2022\0225 Auditin 4 Gazar-40.Docx

0001090141



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 219/20150458

Улаанбаатар хот

АХГ-2022/345/НА-ОА-ТМЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст 35 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 11 удаагийн 358,998,000.00 төгрөгийн ажил, гүйлгээний мэдээлэл, дараа жилийн төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны тайланг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Тунгалагт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 217/АО150458

Улаанбаатар хот

АХГ-2022/345/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын удирдлага дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйгээс бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдэлд бүртгэлээр тавих хяналт суларч, өмнөх онуудад зарцуулсан бараа материалын үлдэгдэл 957,928,121.00 мянган төгрөгийг зардалд тусгаж, тайлант хугацааны үр дүнг бууруулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана": түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгийн худалдан авалт, зарцуулалт, үлдэгдэлд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Тунгалаг нягтлан бодогч Б.Золзаяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

99019120596

\\p101020\audit\shereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Газар-231.Docx

0010800725



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 218/2015 0458

Улаанбаатар хот

АХГ-2022/345/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүйгээр халагдсан ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 9,258,950.00 төгрөгийг байгууллагаас олгосон байна.

Энэ нь Захиргааны Ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", 103.2 "Энэ хуулийн 103.1-д "Гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шүүхийн шийдвэрээр ажилтанд олгосон 9,258,950.00 /Есөн сая хоёр зуун тавин найман мянга есөн зуун тавин/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч, алдаа, зөрчлийг арилган, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Алтансүхт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.НАСАНБУЯН

1006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.20\Bichig_Kherag\Alban_Shaardloga\2022\0225 Auditin 2 Газар-232.Docx

0010800748

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing the summary.

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing the conclusion.